

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ	2
2. 2. Аудитын тайлан	2
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. 3. Менежментийн захидал	9
4. 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
5. 4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт
ЗГТС	Засгийн газрын тусгай сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА Г.ЭРДЭНЭБАТ
ТАНАА

2020.03.13 № 06/785
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого. Журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Төслийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, "Олон Улсын Монгол судлалын холбоо"-оос хэрэгжүүлж буй "Дэлхийд тархсан Монгол өв" цуврал 4 боть каталог бүтээх төслүүдийн гэрээний хугацаанд дуусаагүй, актаар хүлээлгэж өгөөгүй байхад гэрээний үлдэгдэл төлбөр 20.0 сая төгрөгийг шилжүүлсэн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Үүрэг, хариуцлага

Соёл урлагийг дэмжих сангийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын дарга Ж.Эрдэнэбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 12-оос 2020 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал, чанарын хяналтын менежер Д.Нямдорж, аудитор Т.Батсайхан нар хариуцаж хэрэгжүүлэв.

Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 1/17 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Соёл урлагийг дэмжих сангийн зорилго нь “Монголын үндэсний болон сонгодог урлагийг хөгжүүлэх, түүх соёлын дурсгалыг хамгаалах, сонгодог урлаг, ардын урлаг, хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжиж, хөгжмийн болон дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын сан хөмрөгт худалдан авах, төв, орон нутгийн нийтийн номын сангийн фонтыг баяжуулах зэрэг дэмжлэг үзүүлэх” гэж тодорхойлжээ.

Соёл урлагийг дэмжих сан нь төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сонгодог урлаг, ардын урлаг, хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжиж, хөгжмийн болон дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын сан хөмрөгт худалдан авах, төв, орон нутгийн нийтийн номын сангийн фондыг баяжуулах зэрэгт дэмжлэг үзүүлэх гэж үйл ажиллагаа чиглэлийг тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлт
- Нийгмийн даатгалын тухай хуульд шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Соёл урлагийг дэмжих сан нь хуулийн этгээд биш тул Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй болно.

Соёл урлагийг дэмжих сангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн “Accolous 3.0” программ хангамж ашигласан байна.

Соёл урлагийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Соёл урлагийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,950.0 сая төгрөгөөс тооцон 19.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 20.4 сая төгрөгөөр тооцсон нь 2019 оны санхүүгийн үр үр дүнгийн тайлангаарх нийт зардлын дүн 92.0 сая төгрөг буюу 4.7 хувиар өссөнтэй холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Соёл урлагийн дэмжих сангийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50.0 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал	50.0	-	50.0
Нийт хөрөнгө	50.0	-	50.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	50.0	-	50.0

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл буурсан нь Соёл, урлагийг дэмжих сангаас 2018-2019 онд хэрэгжих Чойжин ламын сүм музейн “Монгол урлаг” цомог хэвлүүлэх, Ю.Цэдэнбал даргын бүтэн биеийн лааны тосон баримал, Бөмбөгөр ногоон театр гэрэл зургийн цомог, нийт 3 төслийн гэрээт ажил 2019 онд хэрэгжиж дууссанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 50.0 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны урьдчилж гарсан зардлын зарцуулалт, тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 2,000.0 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт 65 төсөл арга хэмжээнд БСШУС-ын сайдын 2019 оны А/350 дугаар тушаалаар 1,170.0 сая, А/30 дугаар тушаалаар 30.0 сая, А/262 дугаар тушаалаар 800.0 сая, нийт 2,000.0 сая төгрөгийг соёл урлагийг дэмжих сангийн орлогоос санхүүжүүлэхээр төсөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 2,000.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх төсөв батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,992.0 төгрөгийн орлого бүрдүүлж ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,990.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь 10.0 сая төгрөг нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлын хэмнэлттэй холбоотой байна.

Тус сангийн төсвийн захирагч нь 2019 онд 1,992.0 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны урсгал зардалд 1,990.0 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 2.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэлийн шатанд нийт 10 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 35.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 20.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 15.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. Үүнд:

- БСШУС-ын сайдын 2019 оны А/350 тушаалаар “Олон Улсын Монгол судлалын холбоо”-оос хэрэгжүүлж буй “Дэлхийд тархсан Монгол өв” цуврал 4 боть каталог бүтээх төсөлд 100.0 сая төгрөг зарцуулах шийдвэрийн дагуу БСШУС-ын яамны Соёл урлагийн бодлогын газар, “Олон улсын монгол судлалын холбоо”-той 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдөр СУБГ-2019/214 дугаар гэрээ байгуулж, гэрээний хугацаа дуусаагүй, ажлыг бүрэн хийж, актаар хүлээлгэн өгөөгүй байхад гэрээний үлдэгдэл төлбөр 20.0 сая төгрөгийг шилжүүлсэн. Энэ нь 7.3-д “Ажлыг бүрэн дуусган, анхан шатны баримтыг ирүүлж, гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш ажлын 7 хоногт үлдэгдэл 20 хувийн санхүүжилт 20.0 сая төгрөгийг гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн олгоно” заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 15.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

БСШУС-ын сайдын 2019 оны А/361 тушаалаар (Соёл урлагийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт, санхүүжилт)-ийн соёл урлаг, хөгжүүлэх зардлын 6 арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах нийт 270.5 сая төгрөгийн зарцуулах эрхийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын дарга Г.Эрдэнэбатад шилжүүлсэн байна. Хөрөнгийн зарцуулалтыг тус байгууллагыг шалгаж байгаа аудитын байгууллага хянах үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.12. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Соёл урлагийг дэмжих сан нь БСШУС-ын сайдын багцад багтдаг тул Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг БСШУС-ын сайдын цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Соёл урлагийг дэмжих сан нь БСШУС-ын сайдын багцын шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэл тавьдаг гэх боловч нэг ч мэдээлэл тавиагүй байна.

2.13. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, нийт 3 зөвлөмж өгснөөс, албан шаардлага болон зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.14. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль,

УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсгийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой.

3.1.1 Илрүүлэлт:

БСШУС-ын сайдын 2019 оны А/350 дугаар тушаалаар “Ерөөлч магтаалч хүүхдийн улсын уралдаан” төслийн 5.0 сая, Туульс хайлдаг-2” төслийн 10.0 сая, нийт 15.0 сая төгрөгийн төслийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтгүй. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна: 20.1.4 хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” заалтуудыг зөрчсөн.

3.1.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэж, хууль журам зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэлтэд тавих хяналтыг сайжруулж, баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэж тайлагнахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Үйлчлүүлэгч байгууллагын хариу:

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,000,000.00	-
48	УРЬДЧИЛГАА	50,000,000.00	-
54	Урьдчилж гарсан зардал	50,000,000.00	-
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	50,000,000.00	-
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	50,000,000.00	-
215	Засгийн газрын хувь оролцоо	50,000,000.00	-
223	Хуримтлагдсан үр дүн	50,000,000.00	-
225	Тайлант үеийн үр дүн	50,000,000.00	-
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	50,000,000.00	-

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,000,000,000.00	1,992,000,000.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,000,000,000.00	1,992,000,000.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	2,000,000,000.00	1,992,000,000.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,000,000,000.00	1,992,000,000.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,950,000,000.00	2,042,000,000.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,950,000,000.00	2,042,000,000.00
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,858,586,470.00	2,040,000,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	450,000,000.00	553,000,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	450,000,000.00	553,000,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	1,408,586,470.00	1,487,000,000.00
210	Бараа үйлчилгээний бусад зардал	1,408,586,470.00	1,487,000,000.00
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,413,530.00	2,000,000.00
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	91,413,530.00	2,000,000.00
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,413,530.00	2,000,000.00
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	50,000,000.00	(50,000,000.00)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	50,000,000.00	(50,000,000.00)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,000,000,000.00	1,992,000,000.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,000,000,000.00	1,992,000,000.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	2,000,000,000.00	1,992,000,000.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,000,000,000.00	1,992,000,000.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,000,000,000.00	1,992,000,000.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	2,000,000,000.00	1,992,000,000.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,908,586,470.00	1,990,000,000.00
94	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000,000.00	499,000,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	500,000,000.00	499,000,000.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	1,408,586,470.00	1,491,000,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	1,408,586,470.00	1,491,000,000.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,413,530.00	2,000,000.00
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	91,413,530.00	2,000,000.00
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,413,530.00	2,000,000.00
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1.	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3.	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4.	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
5.	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
6.	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
7.	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	-	-
8.	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	50,000,000.00	50,000,000.00
9.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
10.	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	50,000,000.00	50,000,000.00
11.	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
12.	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
13.	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
14.	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
15.	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(50,000,000.00)	(50,000,000.00)
16.	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2.0	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,000,000,000.0	1,990,000,000.0	10,000,000.0	99.5
3.0	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,000,000,000.0	1,990,000,000.0	10,000,000.0	99.5
4.0	Бараа, үйлчилгээний зардал	2,000,000,000.0	1,990,000,000.0	10,000,000.0	99.5
43.0	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	500,000,000.0	499,000,000.0	1,000,000.0	99.8
44.0	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000,000.0	499,000,000.0	1,000,000.0	99.8
53.0	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000,000.0	1,491,000,000.0	9,000,000.0	99.4
54.0	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000,000.0	1,491,000,000.0	9,000,000.0	99.4
97.0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,000,000,000.0	1,990,000,000.0	10,000,000.0	99.6
98.0	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,000,000,000.0	1,990,000,000.0	10,000,000.0	99.6
99.0	Улсын төсвөөс санхүүжих	2,000,000,000.0	1,990,000,000.0	10,000,000.0	99.6
127.0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128.0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129.0	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130.0	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
133.0	АЖИЛЛАГСДЫН ТОО	2	2	-	-
135.0	Гүйцэтгэх ажилтан	2	2	-	-
136.0	Үйлчлэх ажилтан			-	-

4. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2019.12.31			САГ-2020/18/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Соёл урлагийг дэмжих сан		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн сая.төг	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	БСШУС-ын сайдын 2019 оны А/350 дугаар тушаалаар “Ерөөлч магтаалч хүүхдийн улсын уралдаан” төслийн 5.0 сая, Туульс хайлдаг-2” төслийн 10.0 сая, нийт 15.0 сая төгрөгийн төслийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтгүй байна. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна: 20.1.4 хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” заалтуудыг зөрчсөн.	15.0	Зөвлөмж өгөх	Соёл урлагийн газрын дарга, Нягтлан бодогч	Г.Эрдэнэбат, А.Түвшин
2	БСШУС-ын сайдын 2019 оны А/350 тушаалаар “Олон Улсын Монгол судлалын холбоо”-оос хэрэгжүүлж буй “Дэлхийд тархсан Монгол өв” цуврал 4 боть каталог бүтээх төсөлд 100.0 сая төгрөг зарцуулах шийдвэрийн дагуу БСШУС-ын яамны Соёл урлагийн бодлогын газар, “Олон улсын монгол судлалын холбоо”-той 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдөр СУБГ-2019/214 дугаар гэрээ байгуулж, гэрээний хугацаа дуусаагүй, ажлыг бүрэн хийж, актаар хүлээлгэж өгөөгүй байхад гэрээний үлдэгдэл төлбөр 20.0 сая төгрөгийг шилжүүлсэн.	20.0	Албан шаардлага хүргүүлэх	Соёл урлагийн газрын дарга, Нягтлан бодогч	Г.Эрдэнэбат, А.Түвшин
	Дүн	35.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 16

№ 02/115

Улаанбаатар хот

С/аг-2020/18/СТА - ЗГТС
Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Соёл урлагийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. БСШУС-ын сайдын 2019 оны А/350 тушаалаар "Олон Улсын Монгол судлалын холбоо"-оос хэрэгжүүлж буй "Дэлхийд тархсан Монгол өв" цуврал 4 боть каталог бүтээх төсөлд 100.0 сая төгрөг зарцуулах шийдвэрийн дагуу БСШУС-ын яамны Соёл урлагийн бодлогын газар, "Олон улсын монгол судлалын холбоо"-той 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдөр СУБГ-2019/214 дугаар гэрээ байгуулж, гэрээний хугацаа дуусаагүй, ажлыг бүрэн хийж, актаар хүлээж аваагүй гэрээний үлдэгдэл төлбөр 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэрээний 7.3-д "Ажлыг бүрэн дуусган, анхан шатны баримтыг ирүүлж, гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш ажлын 7 хоногт үлдэгдэл 20 хувийн санхүүжилт 20.0 сая төгрөгийг гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн олгоно" заалтыг зөрчсөн байна. /1 боть каталог ном гарсан байна/

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх ажлуудыг хүлээн авах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар анхаарч ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг соёл, урлагийн газрын дарга Г.Эрдэнэбат, нягтлан бодогч А.Түвшин нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Б.ЦЭРЭНДОРЖ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ"
ХХК-ИЙН АУДИТОР

Т.БАТСАЙХАН

ЗӨВШӨӨРСӨН:

СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
Г.ЭРДЭНЭБАТ
НЯГТЛАН БОДОГЧ

А.ТҮВШИН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10\Richie_Kherep\Alban Shaardlaa\2020\03165464.Docx

001080400